



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХҮЧНЭГТ

| Баримт бичгийн нэр | Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам | | |
|---------------------------------|---------------------------------------|--|------------|
| Баримт бичгийн дугаар | NC-Ж-15-05/1.0 | | |
| Баримт бичгийн нууцлалын зэрэг | Нууц | | |
| Боловсруулсан | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
| 1 Ч.Баярмаа | ГҮГ-ын менежер | | 2022/12/15 |
| Хянасан | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
| 1 Э.Золбоо | ГҮГ-ын захирал | хянасан | 2023/01/10 |
| 2 С.Бурмаа | ЭҮГ-ын захирал | хянасан | 2023/01/19 |
| 3 С.Сугардалай | Хуульч | хянасан | 2022/12/16 |
| 4 С.Оргодол | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| 5 Б.Мөнхжавхаяа | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| 6 А.Урангоо | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| 7 Л.Оргил | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| 8 Б.Болорчимэг | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| 9 Т.Жавхлан | ТҮЗ-ийн хараат бус гишүүн | хянасан | 2023/01/13 |
| Баталсан | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
| 1 Д.Алтангэрэл | ТҮЗ-ийн дарга |  | |
| Баримт бичгийн батлагдсан огноо | 2023 оны 01 сарын 16 -ны өдөр | | |
| Баримт бичгийн хариуцагч | Гүйцэтгэх удирдлагын газар | | |
| Хувилбар | 01 | | |

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ


| Хувилбар дугаар | Өөрчлөлт оруулсан бүлэг | Өөрчлөлтийн товч утга | Шинэчилсэн албан тушаалтан | Огноо |
|-----------------|-------------------------|-----------------------|----------------------------|---------|
| 01 | - | Анхны хувилбар | Ч.Баярмаа | 2022/12 |

ЦАХИМ ХАДГАЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Баримт бичгийн хадгалагдаж фолдерын нэр | Цахимаар баримт бичиг хадгалагдаж буй газрын линк |
| | |

АГУУЛГА

| | |
|--|----------|
| Нэг. Зорилго | 3 |
| Хоёр. Хамрах Хүрээ | 3 |
| Гурав. Нэр томьёоны тайлбар | 3 |
| Дөрөв. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн илрэх хэлбэр | 3 |
| Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавигдах шаардлага, хэлцэл хийх журам | 3 |
| Зургаа. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй байх тохиолдлууд | 4 |
| Долоо. Хариуцлага | 4 |



Нэг. Зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь Нэткапитал финанс корпораци ББСБ (цаашид “Групп” гэх) ХХК болон группийн хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах Хүрээ

2.1. Энэхүү журмыг группийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) болон бусад дотоод мэдээлэл эзэмшигч нар дагаж мөрдөнө.

Гурав. Нэр томъёоны тайлбар

3.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- 3.1.1. “Сонирхлын зөрчил” гэж хувь хүний хувийн сонирхол (заавал мөнгөн хэлбэртэй байх албагүй), албаны үүрэг хоёр хоорондоо харшилж байгаа нөхцөл байдлыг;
- 3.1.2. “Сонирхлын зөрчил бүхий этгээд” гэж Компанийн тухай хуулийн 89.1-д заасныг;
- 3.1.3. “Нэгдмэл сонирхол бүхий этгээд” гэж Компанийн тухай хуулийн 89.2-д заасныг;
- 3.1.4. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж группийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын орлогч, газрын захирал болон тэдгээртэй холбоотой этгээдүүдийг;
- 3.1.5. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хууль болон группийн дүрэмд заасны дагуу тодорхойлсон албан тушаалтныг;
- 3.1.6. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж сонирхлын зөрчил бүхий этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа группийн хийж байгаа хэлцлийг;
- 3.1.7. “Сонирхлын зөрчилтэй субъект” гэж хувьцаа эзэмшигч, нэгдмэл сонирхол бүхий этгээд, эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчлийг;

Дөрөв. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн илрэх хэлбэр

4.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:

- 4.1.1. **Өөртэйгээ хийх хэлцэл:** Группийн захирал, эрх бүхий этгээдүүд нь хариуцсан ажлынхаа дагуу ямар нэг гэрээ, хэлэлцээр байгуулахад өөрөө օролцож, шийдвэр гаргаж ямар нэг байдлаар ашиг олох хэлцэл;
- 4.1.2. **Таниелинг:** Группийн 50%-с дээшхи хувьцаа эзэмшигч болон өндөр түвшний удирдлагууд Группийг ашиглан хувьдаа ашиг олох зорилготой хэлцэл
- 4.1.3. **Дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд орох замаар хийгдсэн хэлцэл:** группийн дотоод мэдээллийг өөртөө ашигтайгаар ашиглаж, ялангуяа нууцлалтай мэдээлэл болон дотоод мэдээллийн үндсэн дээр хийх хэлцэл
- 4.1.4. **Бэлэг авсаны дагуу хийх хэлцэл :** эрх бүхий албан тушаалтан Группийн ямар нэг бизнесийн харилцаанд орж байгаа гуравдагч этгээдээс бэлэг авч түүнд ашигтай хэлцэл байгуулах
- 4.1.5. **Өөр байгууллагад давхар ажил эрхэлсэнээс үүсэх зөрчил:** Хэрэв группийн ажилтан, албан хаагч нь нэгээс илүү өөр компанийд ажилладаг бол тухайн ажилтны ажиллаж буй компанийн ашиг сонирхол нь хоорондоо зөрчилдөхгүй байх
- 4.1.6. **Гэр бүлийн сонирхолоос үүсэх зөрчил:** группийн захирлын хүүхэд, эхнэр нөхөр болон бусад ойрын төрлийн хамаатан, саднаа ажилд авах явдал ба шударга бусаар буюу үндэслэлгүйгээр цалин нэмэх, албан тушаал ахиулах болон бусад мөнгөн тусlamж олгох зэргээр тухайн этгээдэд ашигтай байдлыг үүсгэх хэлцэл

Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавигдах шаардлага, хэлцэл хийх журам

- 5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь ТУЗ-д дараах зүйлсийг хэлцэл хийхээс хийхээс өмнө бичгээр мэдээлж, зөвшөөрөл авах үүрэгтэй:
- 5.1.1. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшидэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

- 5.1.2. Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;
- 5.1.3. Группийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;
- 5.1.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.
- 5.1.5. Групп өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй
- 5.2. Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийж болно. Үүнд:
- 5.2.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.
- 5.2.2. Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу ТУЗ тогтооно.
- 5.2.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх)-д оруулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар гаргана.
- 5.2.4. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийнэ.
- 5.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.
- 5.4. Групп өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангана.
- 5.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол Групп жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж нийтэд мэдээлнэ.

Зургаа. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй байх тохиолдлууд

- 6.1. Дараах тохиолдлуудыг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцохгүй. Үүнд:
- 6.1.1. Бүх хувьцаа эзэмшигчид нь хэлцэлд сонирхол бүхий;
- 6.1.2. Хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх;
- 6.1.3. Хэлцэл байгуулсны дараа нэгдмэл сонирхолтой этгээд болох;
- 6.1.4. Групп хувьцаагаа эргүүлж худалдаж авах;
- 6.1.5. Группийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан.

Долоо. Хариуцлага

- 7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ, Группэд учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
- 7.2. Сонирхлын зөрчил бүхий этгээд нь Групп буюу түүний хараат, охин компанийд учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлэж, гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 7.3. Группийн энгийн хувьцаа эзэмшигч болон Группийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Хавсралт 1

Сонирхлын зөрчилтэй хэлцэл бүртгэх хуудас

1. Группийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Группийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанийтай дор дурдсан харилцаанд орсон бол “СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ”-д тооцож бүртгэнэ.

- Хэлцлийн нөгөө тал эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн албан хувьцааны /ногдол хувийн/ 20-иос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

| № | Хэлцлийн мэдээлэл | | | | Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох хуулийн үндэслэл |
|---|--------------------|--------------|-------|--------------|--|
| | Хэлцлийн нөгөө тал | Хэлцлийн нэр | Огноо | Хэлцлийн дүн | |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |

2. ХЭХ болон ТҮЗ-ийн хурлын сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тогтоол, шийдвэрийн эх хувийг энэхүү бүртгэлийн хавсралтаар хадгална.

Хавсралт 2

Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх хуудас

1. Групптэй дараах хамаарлтай этгээдийг “**НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД**”-д тооцож бүртгэнэ.Үүнд:

- 1.1. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн группийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;
- 1.2. Группийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд группийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
- 1.3. Группийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн (*бүлэг хүмүүс*) ;
- 1.4. Нэг гэр булийн гишүүн, эцэг эх, хүүхэд, ач зээ нар, ах дүү, бусад төрөл, садны хүн;
- 1.5. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшидэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан;
- 1.6. Нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид;

| № | Нэр | Нэгдмэл сонирхолтойд тооцогдох хамаарал (хуулийн үндэслэл) | Хувьцааны хамаарал | | |
|---|-----|---|--------------------|-----|--------------|
| | | | Төрөл | Тоо | Эзэмшил хувь |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |

2. Нэгдмэл сонирхолтой этгээд нь нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцогдох хамаарал нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд тус үйл баримтын талаар Группт ажлын 5 (тав) хоногийн дотор мэдэгдэнэ.